



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatrural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2021.10.01. № 36

Г Асуулга тавих тухай

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед Засгийн газрын хариуцлагагүй байдлаас шалтгаалан ачаа тээвэрлэлт саатан, шатахууны хомсдол үүссэнээр бараа бүтээгдэхүүний суурь үнэ өсч, иргэдийн бодит орлого бууран нийгэм, эдийн засгийн хямралт байдлыг үүсгээд байна. Хэдийгээр шатахуун хомсдолт байдал тодорхой хугацаанд шийдвэрлэгдсэн ч гэсэн цаашид ийм эрсдэлт байдал үүсэхгүй гэх баталгаа байхгүй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна:

1.Шатахууны хомсдолтой байдал үүсэхэд хоёр улсын Засгийн газар хооронд аливаа нэг үл ойлголцол байгаа эсэх, хойд хөршийн шатахуун, эрчим хүчний эх үүсвэрийн хамраалаас гарах бодит төлөвлөгөө, авч хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ байгаа эсэх;

2.БНХАУ-аас татан авах ачаа тээвэр, ложистикийн хүндрэл болон нүүрс, бусад түүхий эдийн экспортод тавигдаж буй хориг хязгаарлалтуудын ард Засгийн газар хоорондын үл ойлголцол байгаа эсэх, цаашид экспорт хийх сувгаа нэмэгдүүлж, хил, гааль, ачаа тээвэрлэлт, боомтын үйл ажиллагааг өргөжүүлэн экспортыг ядаж Ковидын өмнөх түвшинд хүргэх бодит төлөвлөгөө байгаа эсэх талаар зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлж, шаардлагатай тохиолдолд Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн гишүүдийг байлцуулан, Улсын Их Хурлын чуулганы хаалттай хуралдаанд танилцуулга хийнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Т.ДОРЖХАНД

2020000193